



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ  
Төрийн Өмчит Хувьцааг Компани

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/93

Улаанбаатар хот

### Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

Сангийн яамнаас шинэчилж нэвтрүүлсэн шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээллийн санд компанийн мэдээ, тайланг үнэн зөв, цаг хугацаанд нь байршуулах ажлыг эрчимжүүлж, холбогдох албан тушаалтнуудын сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор ТУШААХ нь

1. Компанийн шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээлэл, хугацаа, хариуцах албан тушаалтан, мэдээллийн хэлбэрийг хавсралтаар баталсугай.

2. Компанийн шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг үнэн зөв, тогтоосон хугацаанд, тогтоосон хэлбэрээр байршуулж ажиллахыг энэхүү тушаалын хавсралтад нэр дурдагдсан нийт албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

3. Компанийн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийн нэгдсэн тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны дотор Сангийн яаманд цахимаар, улирал бүрийн дараа сарын 15-ны дотор Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газарт бичгээр тайлагнаж байхыг Дотоод аудитын ажилтан Д.Болормаад даалгасугай.

4. Энэхүү тушаалын хавсралтад заасны дагуу компанийн шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулахаар нэр заагдсан албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолтод холбогдох нэмэлт оруулж батлуулахыг Хүний нөөцийн менежер Г.Пүрэвцогтод даалгасугай.

5. Энэхүү тушаалын биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтсийн дарга М.Гантөгсөд үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалын хавсралтаар компанийн шилэн дансны цахим хуудсанд байрлуулах мэдээлэл, хугацаа, хариуцах албан тушаалтан, мэдээллийн хэлбэрийг шинэчлэн баталсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2014 оны "Журам батлах тухай" А/64 дугаар тушаалаар батлагдсан "Цахим хуудас хөтлөх тухай журам"-ын 4 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.


7. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2016 оны "Тушаалд өөрчлөлт оруулах тухай" А/02 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.Х.ЭРЛЭН

0000000486



“Монголын төмөр зам” ТӨХК-ийн шилэн дансны цахим хуудаст мэдээлэл тавих хуваарь

ДД	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийн агуулга	Хуулийн заалт	Журмын заалт	Мэдээлэл байршуулах хугацаа	Хариуцах албан тушаалын нэр	Мэдээлэл байршуулах албан хаагчийн нэр	Маягтын загвар баталсан хавсралт, мэдээллийн хэлбэр
1	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр	6.4.8	4.1.13	Тухай бүр	Нягтлан бодогч	Б.Сарантуяа	Журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу, PDF форматаар
2	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	6.3.6	4.1.9	Тухай бүр	Худалдан авалтын мэргэжилтэн	Б.Ундрах	Журмын 7 дугаар хавсралтад заасан маягтын дагуу
3	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл	6.10	8.2	Тухай бүр	Худалдан авалтын мэргэжилтэн	Б.Ундрах	PDF форматаар
4	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	6.1.1	5.2.2	Бүтэн жил 1 дүгээр сарын 10	Худалдан авалтын мэргэжилтэн	Б.Ундрах	Журмын 21 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу
5	Худалдан авах ажиллагааны тайлан	6.4.3	5.1.1	Бүтэн жил 1 дүгээр сарын 15	Худалдан авалтын мэргэжилтэн	Б.Ундрах	Журмын 22 дугаар хавсралтад заасан маягтын дагуу

6	Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл	6.8.3	5.2.3	Тухай бүр	Хуулийн мэргэжилтэн	О.Одончимэг	Журмын 18 дугаар хавсралтад заасан маягтын дагуу
7	Концессын мэдээлэл	6.5.8	5.2.1	Тухай бүр	Эдийн засгийн албаны менежер	Б.Оргил	Журмын 15 дугаар хавсралтад заасан маягтын дагуу